



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№105 /319/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.06.07

Цаг үе, үйл явдал

ХААНЫ ЭРЭЛД 19 ДЭХ ЖИЛДЭЭ ...



Тив дэлхийн өнцөг булан бүрээс энх тайвны төлөө зүрх сэтгэлээ нэгтгэн талын Монгол оронд хуран чуулсан 14 орны төрийн далбаа өчигдөр Таван толгой дахь Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд зэрэгцэн намирч, "Хааны эрэлд-2022" энхийг дэмжих ажиллагааны олон улсын сургууль нээлтээ хийж байна.

Энэхүү нээлтийн ёслолын ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, Батлан хамгаалах бодлогын зөвлөх бэлтгэл дэслэгч генерал Ц.Тогоо, АНУ-ын Аляскийн Үндэсний гвардын Нэгдсэн штабын дарга бригадын генерал Вэйн Дон, БХЯ, ЗХЖШ, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага, Гадаадын орнуудаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдууд, цэргийн атташе нар, Монгол талын сургуулийн удирдагч хурандаа Ш.Амарбаясгалан, Америкийн талын сургуулийн удирдагч дэд хурандаа Майкл Тони нарын хүндэт зочид оролцлоо.

Монгол Улсын Зэвсэгт хүчин АНУ-ын Энэтхэг-Номхон далайн командлалтай хамтран "Хааны эрэлд" энхийг дэмжих ажиллагааны сургалт, дадлагыг 2003 оноос эхлэн хоёр талын сургууль хэлбэрээр зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2006 оноос олон улсын сургалт, дадлага болгон өргөжүүлж, өдгөө 19 дахь жилдээ зохион байгуулж байна. Энэ удаагийн сургууль нь 6 дугаар сарын 6-20-ны өдрүүдэд Тавантолгой дахь Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд зохион байгуулагдах бөгөөд Монгол, Америк, Өмнөд Солонгос, Япон, Энэтхэг, Герман, Бангладеш, Малайз, Зүүн-Тимор, Франц, Турк, Канад, Сингапур, Балбын нийт 1000 гаруй цэргийн алба хаагч оролцож байна.

Сургалт, дадлагын хүрээнд бүс нутгийг хамарсан болзолгүй хямралт цагийн байдалд НҮБ-ын цэргийн хүчнийг төлөөлөн үүрэг гүйцэтгэх олон үндэстний батальоны штабын ажиллагааг жигдрүүлэх команд штабын сургууль, тус штабаас гаргасан шийдвэрийг газар оронд

гардан хэрэгжүүлэх салаадын хээрийн сургуулийг явуулна.

Дэлхийн 14 орны цэргүүд команд штаб болон салааны түвшний хээрийн сургалт дадлагын хичээлд хамрагдах бөгөөд салааны түвшний хээрийн сургууль эргүүл, цувааны хамгаалалт, хүмүүнлэгийн тусламж, энгийн иргэдийн хамгаалалт зэрэг хичээлийн 10 цэгээр цэргүүдэд энхийг дэмжих ажиллагааны мэдлэг, чадвар олгох юм. Өөрөөр хэлбэл НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд тулгардаг бүхий л асуудлыг бодит цагийн байдалд тулгуурлан явуулдгаараа онцлогтой.

Сургуулийн онцлог

Манай Улсын энхийг эрхэмлэгч гадаад бодлогын бодит илэрхийлэл, бүс нутаг, олон улсын түвшинд Монголын төр, засгаас дэвшүүлж буй олон санаачилгын дунд цар хүрээ, нэр хүндээрээ түүчээлж Монголын Зэвсэгт хүчний нэрийн хуудас болж буй тус сургууль нь бүс нутагтаа энхийг дэмжих ажиллагааны хамгийн том олон улсын сургууль билээ. Мөн НҮБ-ын цэнхэр дуулгатнуудын эгнээг өргөтгөх, оролцогч орнуудын энхийг дэмжих чадамжийг нэмэгдүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт цэргийн итгэлцэл, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулдаг чухал сургууль юм.

"Хааны эрэлд" сургуулийн хувьд дэлхий нийтэд нүүрлэсэн "COVID-19" цар тахлын нөхцөл байдлын улмаас хоёр жилийн хугацаанд завсарлаад байсан юм. Харин энэ удаагийн "Хааны эрэлд-2022"-д Япон улс анх удаагаа хоёр салаа илгээж, өргөн бүрэлдэхүүнээр оролцож байгаагаараа онцлог. Мөн "Тусгай зочдын хамгаалалт" хичээлийн цэг шинээр нэмэгдсэн юм.

Сургуульд оролцож буй орон орны цэргүүд зөвхөн энхийг сахиулах ажиллагааны арга туршлагаас суралцаад зогсохгүй үе тэнгийн залуусын хувиар найзлан нөхөрлөж, спорт, урлагийн арга хэмжээнд оролцож, ахан дүүс болдог орооно онцлогтой.

"БАГАБАЯН"-ЧУУД ЗУН ЦАГИЙН НЭЭЛТЭЭ ХИЙЛЭЭ

Өдгөө 90 жилийн түүхийг өртөөлж буй "Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв" ТӨААТҮГ өнгөрөгч Бямба гарагт зуны улирлын нээлтийн арга хэмжээг зохион байгуулж Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын хамт олны тоглолтоор амрагч олны сонирхлыг мялаасан юм.

Энэ үеэр тус байгууллагын захирал бэлтгэл бригадын генерал Б.Ганбаатар "Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв" нь анх 1932 оноос эхэлж үйл ажиллагаагаа эхэлж байснаараа манай орны анхны амралтуудын нэгд тооцогддог. Манай байгууллагын үйл ажиллагаа нь аялал жуулчлал, амралт үйлчилгээ,

батлан хамгаалах салбарын алба хаагчид болон тэтгэвэр чөлөөнд гарсан ахмадуудаа хүлээн авч алжаал ядаргааг нь тайлах, сувилан тэнхрүүлэх зорилготойгоор анх байгуулагдаж байсан түүхэн онцлогтой. Бид цаашид үйл ажиллагааныхаа чиглэлийг өргөжүүлж амрагчдыг ая тухтай нөхцөл боломжоор хангах чиглэлд багагүй ажил, арга хэмжээг зохион байгуулж байна. Ингээд "Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв"-ийн зуны үйл ажиллагааны нээлт ийнхүү эхэлж байгааг баяртайгаар уламжилж байна" хэмээв.



ХОЁР СУРГУУЛИЙН БАГШ НАР ХАРИЛЦАН ТУРШЛАГА СОЛИЛЦОНО



Нийслэлийн тэргүүний Ерөнхий боловсролын "Тэмүүжин Өрлөг" сургууль, гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай Нийслэлийн Ерөнхий боловсролын лаборатори 23 дугаар сургуулиудын хамтын ажиллагааны эхлэл тавигдаж, санамж бичиг байгууллаа. Энэхүү санамж бичгийг Нийслэлийн Тэргүүний "Тэмүүжин Өрлөг" сургуулийн захирал, докторант хурандаа Д.Бат-Эрдэнэ, Нийслэлийн

Ерөнхий боловсролын лаборатори 23 дугаар сургуулийн захирал Ц.Цолмонбаатар нар үзэглэв. Хамтын ажиллагааны хүрээнд багш нарын сурган хүмүүжүүлэх, сургалт арга зүйн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, багш сурагч солилцооны хөтөлбөр, эх оронч үзэл хандлагыг сурагчдад эзэмшүүлэхэд чиглэгдсэн олон ажлыг төлөвлөж байгаа юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 14	🌧️ 4

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	🌧️ 25

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,123.00	3,127.0
EUR 🇪🇺	3,355.0	3,365.0
CNY 🇨🇳	469.00	471.00
RUB 🇷🇺	46.00	46.50
JPY 🇯🇵	24.00	24.30
KRW 🇰🇷	2.51	2.53

ЗУРХАЙ



2022.06.07 /МЯГМАР ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 8

ЗУНЫ ИЛҮҮ ТЭРГҮҮН САРЫН ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Нас уртасна

Наран ургах, шингэх:
04.54-20.48

Барилдлага:

Арвидах

Шүтэн барилдлага:

Өтлөх үхэхүй

Суудал: Огторгуй

Энэ өдөр хонь, гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, гарагийг тахиж, мал аж ахуйн үйл, удирдлагын суудалд суух, хийморийн дарцаг хатгахад сайн. Газар хагалах, ус булгийн эх малтах, улаа гаргах, хиншүү хярвас гаргах, уул овоо тахилахад муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал нас уртадна.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 535,761,218

Эдгэрсэн

Нийт: 506,754,056

Нас барсан

Нийт: 6,321,260

Цахим шууданд

АЛБА ХААЖ БУЙ ЦЭРГИЙН АР ГЭРТ ӨРГӨӨ ЦАГААН ГЭР ӨГЛӨӨ



нийслэл дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын тоо бүртгэлийн офицерууд, 18 дугаар хорооны Засаг дарга, түүний ажлын албаны бүрэлдэхүүн албан хаагчийн ар гэрт өргөө цагаан гэрийг гардуулан өглөө. Энэ үеэр Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн удирдлагатай харилцан ажиллагааг зохион байгуулж хугацаат цэргийн алба хааж байгаа байдагч

Чингэлтэй дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб
Чингэлтэй дүүргээс 2021 онд хугацаат цэргийн албанд татагдан Зэвсэгт хүчний 338 дугаар ангид алба хааж байгаа 18 дугаар хорооны иргэн Э.Энхманлайгийн ар гэрт 5 ханатай иж бүрэн өргөө цагаа гэрийг хүлээлгэн өглөө.

Тус ажлыг Батлан хамгаалахын сайд болон нийслэлийн Засаг даргын 2022 хамтран ажиллах санамж бичгийн дагуу хугацаат цэргийн албанд татагдсан дайчдыг хоёргүй сэтгэлээр алба хаах нөхцөл боломжийг хангах хүрээнд нийслэл, дүүргүүдийн Цэргийн штабын Тоо бүртгэлийн офицеруудын санаачлагчаар нийгмийн хариуцлагын хүрээнд зохион



байгуулсан юм.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Г.Ялалт, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга дэд хурандаа О.Мөнхжаргал,

Э.Энхманлайтай цахимаар холбогдон Нийслэл, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын удирдлагын зүгээс ар гэртэй санаа зоволгүй хугацаат цэргийн албаа нэр төртэй хааж ирэхийг хүслээ.

ХҮҮХДИЙН БАЯРЫН ӨРГӨН ДЭЛГЭР ТЭМДЭГЛЭН ӨНГӨРӨӨВ



DOOGEE V10 AI QUAD CAMERA

Зэвсэгт хүчний 234 дүгээр анги

“Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан офицер, ахлагч, ажилтан албан хаагчдынхаа хүүхэд багачуудад хүндэтгэл үзүүлж, баярын арга хэмжээг

зохион байгууллаа. Арга хэмжээг нээж ангийн захирагч хурандаа Г.Эрдэнэбаяр мэндчилгээ дэвшүүлж, авьяаслаг бяцхан багачууд маань дуулж, бүжиглэн, хоорондоо уралдаж, тоглоомор тоглож баяр

хөөрөөр дүүрэн аз жаргал, дурсамжаар дүүрэн нэгэн өдрийг өнгөрүүлээ. Алба хаагчдын хүүхдүүдийн дунд 4 төрлийн тэмцээнийг насны ангиллаар зохион байгуулж шилдгүүдийг шалгаруулан өргөмжлөл, гарын бэлгээр шагнаж урамшууллаа.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД...



Зэвсэгт хүчний 124 дүгээр анги

Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн 148 дугаар тусгай салбарын хамт олон

иргэн цэргийн харилцааг хөгжүүлэх, нийгмийн хариуцлагын хүрээнд Эх үрсийн эрхийг хамгаалах тохиолдуулан



“Ээжээ brand” -тэй хамтран шинээр төрсөн иргэдэд бэлэг гардууллаа.

Тухайлбал, Өмнөговь аймгийн төрөх эмнэлэгт Эх хүүхдийн тав тухтай байдлыг хангасан шинэлэг бүтээгдэхүүн эх хүүхдийн асаргаа, сувилгаа хийх зориулалтын бүүвэйлэгч бүсэлхийн тавируудыг хүлээлгэн өгсөн юм.

Монголын үрс маш олон болох болтугай.

Ахлах дэслэгч Д.ЭНХНАСАН

“ДӨЛ” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО

Дархан-уул аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Дархан-Уул аймгийн Засаг даргын нэрэмжит цэргийн спортын “ДӨЛ” цогцолбор тэмцээний нэгд, хоёрдугаар шатны тэмцээн амжилттай явагдаж өндөрлөлөө.

Нэгдүгээр шатны тэмцээнийг аймгийн Ерөнхий боловсролын 25 сургууль дотооддоо зохион байгуулан сургууль тус бүрээс шалгарсан багуудыг аймгийн аварга шалгаруулах цэргийн спортын “ДӨЛ” цогцолбор тэмцээнд оролцууллаа.

Хоёрдугаар дугаар шатны тэмцээнд Дархан сумын Ерөнхий боловсролын 9 сургуулийн 117 сурагчид хурд хүч, авхаалж самбаа, авьяас чадвар, мэдлэг оюунаа сорин өрсөлдсөнөөс тэргүүн байранд Дархан сумын Ерөнхий боловсролын “Од” сургуулийн “Хар сүлд” тасаг шалгарч шилжин явах цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал, дэд байранд Дархан сумын ерөнхий боловсролын “Оюуны ирээдүй” сургуулийн “Соёмбо” тасаг, гутгаар байранд Дархан сумын Ерөнхий боловсролын 15 дугаар сургуулийн “Хан гардиуд” тасгууд тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Тэмцээний шагнал гардуулах үйл ажиллагааг олон улсын энхийг сахиулагчийн баяр, Монгол Улс энхийг сахиулах ажиллагаанд оролцож



эхэлсний 20 жилийн ойн баярын арга хэмжээний хүрээнд Зэвсэгт хүчний 330 дугаар ангитай хамтран Залуучууд театрын талбайд

зохион байгуулж хүүхэд, залуучууд, ард иргэдэд Батлан хамгаалах бодлого үйл ажиллагаа, Зэвсэгт хүчнээ сурталчиллаа.

САРЫН АЖЛАА ДҮГНЭЖ ШИЛДГҮҮДЭЭ ТОДРУУЛАВ



Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Ангийн сахилгын дүнгийн хурлыг зохион байгуулав. Хурлын хүрээнд салбар нэгжийн дарга илтгэгч нар хийсэн ажил болоод хийж гүйцэтгэж буй ажлаа нийт бие бүрэлдэхүүнд уншиж танилцуулахын зэрэгцээ цаашид авч хэрэгжүүлэх болон анхааран ажиллах арга хэмжээний тайлангийн удирдлагаас

үүрэг чиглэл өгөв. Мөн энэ үеэр Батлан хамгаалахын сайдын 2022 оны тушаалаар хариуцсан ажил албандаа үлгэр жишээ болж, хамт олноо манлайлсан Ахлах ахлагч Н.Цолмон, Б.Өлзий сайхан, Б.Пүрэв, Д.Уранчимэг, М.Алтанбаатар, Л.Намсрай, А.Лэгшиг, Г.Өлзийбаяр, Л.Шархүү, Б.Отгондалай, С.Батцэцэг, Д.Батдэлгэр, ахлагч Д.Буян-Өлзий нарын барилгачин дайчдыг

“Дайчин алдар” III медалиар шагнаж урамшууллаа. Үргэлжлүүлэн Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хариуцсан ажилдаа идэвх санаачилга гарган, хамт олноо манлайлан үр бүтээлтэй ажилласан Т.Цогтбаяр, Б.Сарантуяаг нарыг тус тус 1 өдрийн цалинтай чөлөөгөөр шагнаж урамшууллаа

Ахлагч Н.НАРАНДЭЛГЭР



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
“Соёмбо” сонин
“Дуулга” студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)